

НД №06(41) Нийгмийн даатгал, халамж.

Нийгмийн даатгал:

Нийгмийн даатгалын сангийн орлого 2010 оны эхний хагас жилд 264.1 тэрбум төг, зарлага 241.1 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 11.1 тэрбум төг буюу 4.4 хувь, зарлага 4.7 тэрбум төг буюу 2.0 хувиар тус тус нэмэгдлээ.

Нийгмийн даатгалд 2010 оны эхний хагас жилд 493.9 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 206.6 мянга буюу 41.8 хувь нь төсөвт байгууллагын, 287.3 мянга буюу 58.2 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын даатгуулагчид байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2010 оны эхний хагас жилд 166.0 тэрбум төг болж, үүний 73.1 хувийг өндөр настны, 12.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 7.4 хувийг тэжээгчээ алдсаны, 6.7 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна (Зураг 1).

Нийгмийн халамж:

Энэ оны эхний хагас жилд 171.3 мян.хүнд 23.1 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 1.1 сая хүн буюу 86.7 хувь, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 36.7 тэрбум төг буюу 61.4 хувиар буурчээ. Улсын төсвөөс өмнөх оны мөн үед хүүхдийн мөнгөн тэтгэмж, шинэ төрсөн хүүхдийн мөнгөн тусламж, шинэ гэр бүлд олгосон мөнгөн тусламжийг 1.0 сая хүнд 25.6 тэрбум төг олгосон ба нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн талаарх холбогдох хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу 2010 оны 1-р сарын 1-нээс олгогдохгүй болсон байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын бүтцийг авч үзвэл, 47.5 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмжид, 32.5 хувь нь халамжийн тэтгэвэрт, 9.3 хувь нь ахмад настныг асарч буй иргэний тэтгэмжид, 9.1 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний тэтгэмжид, 1.6 хувь нь бүтэн өнчин хүүхэд үрчилж өсгөсний тэтгэмжид тус тус хамрагдсан байна (Зураг 2).

Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж 2010 оны эхний хагас жилд 12.7 тэрбум төг буюу 55.2 хувийг халамжийн тэтгэвэрт, 6.6 тэрбум төг буюу 28.5 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн, 1.8 тэрбум төг буюу 7.9 хувийг ахмад настныг асарч буй иргэндэд, 1.7 тэрбум төг буюу 7.3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэндэд, 250.1 сая төг буюу 1.1 хувийг бүтэн өнчин хүүхэд үрчилж өсгөсний тэтгэмжид тус тус зарцуулсан байна (Зураг 3).


Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2010 оны эхний хагас жилд 55.7 мян.хүн хамрагдаж, 12.7 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс хамрагдсан иргэдийн тоо 2.5 мян.хүн буюу 4.7 хувиар, олгосон тэтгэврийн хэмжээ 0.7 тэрбум төг буюу 5.7 хувиар нэмэгдсэн байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөнд 217.6 мян.хүн хамрагдсаны 68.5 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 22.0 хувь нь ахмад настнууд, 3.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 3.1 хувь нь алдар цолтой ахмадууд, 2.9 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд байна.

Энэ оны эхнээс эхлэн Хүний хөгжил сангаас иргэн бүрт 70.0 мян.төг олгож байгаа бөгөөд эхний хагас жилд 2.4 сая иргэнд 169.8 тэрбум төг олгосон байна.

Зураг 1

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн бүтэц, 2010 оны эхний хагас жилийн байдлаар, хувиар



Зураг 2

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын бүтэц, 2010 оны эхний хагас жилийн байдлаар, хувиар



Зураг 3

Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц, 2010 оны эхний хагас жилийн байдлаар, хувиар

